



**АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ
НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ТАНИЛЦУУЛГА**

01/2017

ЦЭЦЭРЛЭГ ХОТ




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 518 ор, амбулаторийн 101 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 29.2 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 8.1 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 2.1 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98,8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Цэнхэр сумд 100,0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар




Оны эхний 1 сард 156 эхээс 158 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 102,6 хувиар буюу 4 хүүхдээр илүү байна,

Хүн амын нас баралт 33 гарсан нь өнгөрсөн оныхоос 2 тохиолдлоор буюу 5,7 хувиар бага байна. Мянган хүнд ноогдох төрөлт 1,7, нас баралт 0,3 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 1,4 промил байна. Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл гараагүй, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 1 гарч мянган амьд төрөлтөд 6,3 ногдож

байгаа нь өнгөрсөн оныхоос 3 тохиолдлоор буурсан байна.

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 4 нь буюу 40 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган(10), Ихтамир (9), Жаргалант (7), Төвшрүүлэх(7) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 30,0 хувь нь салхин цэцгээр, 2,5 хувь нь улаан бурханаар, 47,5 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 12,5 хувь нь сүрьеэгээр, 7,5 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 29,8 хувиар буюу 17 тохиолдлоор буурсан байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

2 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1841 ажилгүй хүн байгаагийн 48,4 хувь нь буюу 891 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 329 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс

бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 52,5 хувиар нэмэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98,4 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 428 нь дээд, 116 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 1156 нь бүрэн болон бүрэн бус дунд, 111 нь бага боловсролтой хүмүүс байна.

1 дүгээр сард ажилгүйчүүдийн бүртгэлд 887 хүн шинээр бүртгүүлж, 1069 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж, 19 хүн ажилд зуучлуулан орсон байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 1 сард 3,9 тэрбум төг, зарлага 3,5 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 152,7 сая төг буюу 4,1 хувь, зарлага 299,2 сая төг буюу 9,4 хувиар өслөө.


Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 152,7 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 11,1 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 17,1 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 3 дахин өссөн нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 9,4 хувиар өсөхөд тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн даатгалын сангууд өссөн нь голлон нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 3,2 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 64,6 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 1 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 4,2 мянган хүнд 338,1 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 88,5 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 11,5 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 65,1 хувийг халамжийн тэтгэврээр, 30,0 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 4,9 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвр, тэтгэмжийн бүтэц




ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 53 холбогдогч бүхий 60 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 23, өмчлөх эрхийн эсрэг 31, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 1, байгаль хамгаалах журмын эсрэг 3, бусад 2 хэрэг гарсан байна.


Гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 24 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 175,6 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 26,7 хувийг бүлэглэж 21,7 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 78 хүнийг албадан саатуулж 30 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 9,1 хувиар буюу 5 тохиолдлоор нэмэгдсэний дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 64,3 хувиар буюу 9 тохиолдлоор өсч харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 8,8 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар






ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2017 оны 1 сард аймгийн төсөвт 1905,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2088,0 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 109,6 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 427,2 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 610,0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 142,8 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Ихтамир, Хангай, Тариат, Өндөрүлаан, Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Батцэнгэл, Өлзийт, Цэнхэр, Булган сумд 108,8 хувиас 66 дахин биелүүлсэн байна. Харин Чулуут, Хайрхан, Өгийнуур, Хашаат, Хотонт, Төвшрүүлэх, Эрдэнэбулган, Цахир сумд 3,2-76,5 хувиар тасалсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл хүн амын орлогын албан татвар, газрын төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж, төсөвт байгууллагын өөрийн орлогоос


бусад нэрийн орлогуудыг 100,0 хувиас 21 дахин биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 70,8 хувийг тусламжийн орлогоор, 15,4 хувийг орлогын албан татвараар, 0,7 хувийг өмчийн татвараар, 0,5 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 10,6 хувийг бусад албан татвараар, 2,0 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 10,7 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 32,9 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 0,7 сая төгрөг бүгд 44,3 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 3293,2 сая төгрөг байгаагийн 57,0 хувийг цалин хөлсөнд, 5,7 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 37,3 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 34,0 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 55,9 хувийг боловсролын салбарт, 9,5 хувийг эрүүл мэндийн салбарт, 0,3 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0,3 хувийг бусад салбарт зарцууллаа.

**Орон нутгийн төсвийн байгууллагын
нийт зарлагын бүтэц, хувиар**






МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 950,0 сая төгрөгийг авч 1,2 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 1 сард банкууд 6,3 мянган иргэд, аж ахуй нэгжид 11,2 тэрбум төгрөгийн зээл олгосны дотор 3 хүнд 159,9 сая төгрөгийн орон сууцны зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 1 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн онтой зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 22,6 хувиар өсч анхаарал хандуулах зээлийн хэмжээ 8,4 хувиар багаслаа. Харин олгосон зээлийн хэмжээ 15,5 хувиар багасч чанаргүй зээлийн хэмжээ 89,8 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 1 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф

өмнөх сарынхаас 1,2 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 6,6 хувиар, 2010 оны 12-р сарынхаас 99,5 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 2016 оны 12 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 214 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 10,7 хувийнх нь өсч, 0,5 хувийнх нь үнэ буурч, 88,8 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас парацетамол эмний үнэ 11,1 хувиар буурч харин тараг, сүү, гурилан боов, өөхөн тос, адуу ямааны болон дотор мах, байцаа, лууван, манжин,ногоон цай, угаалгын нунтаг, А-80 бензин зэргийн үнэ 1,3 – 80,0 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 49,1 хувийнх нь буюу 105 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 3,3 хувийнх нь буюу 7 нэрийн барааны үнэ буурч, 47,6 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс төмс, байцаа, бүх төрлийн шатахуун, гар утас, флаш дискний үнэ 6,2 – 44,7 хувиар буурч, харин бүх төрлийн малын мах, хатуу чихэр, цай, давс, тамхи, ундаа, шар,цагаан будаа, алим, элсэн чихэр, сурагчийн цүнх, сурагчийн дөрвөлжин шугамтай дэвтэр, лаа,трико 4-5 настай охидын, хүүхдийн пүүз,эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, даавуу, гэр ахуйн хэрэгсэл, тавилга, оо, саван,тамхи, түлшний мод зэрэг барааны үнэ 1,3- 76,9 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

2 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний мал 99,8 хувиар онд орж оны эхний малын 0,2 хувь буюу 8,7 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 8,1 хувийг адуу, 14,5 хувийг үхэр, 42,3 хувийг хонь, 35,1 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Батцэнгэл, Цахир, Эрдэнэбулган сумд том малын хорогдолгүй байна. Өндөрүлаан, Жаргалант сумдын оны эхний малын 0,5 хувь нь, бусад сумдын малын 0,1-0,3 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



2017 онд манай аймаг ойгоос 100,8 мянган м3 галын түлээ, 12,7 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 113,5 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 1 сард 7,8 мянган м3 галын түлээ, 1,6 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 9,4 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 14,0 сая төгрөг төсвийн орлогод оруулж, ойн зөрчил торгуульд 1,2 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна.




АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 1 сард оны үнээр 894,3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 68,3 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 345,9 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 25,1 хувиар илүү байна.

Нийт үйлдвэрлэлтийн 3,2 хувийг хүнс ундааны, 0,2 хувийг хэвлэлийн, 82,4 хувийг дулааны эрчим хүчний, 8,1 хувийг усан хангамж, 1,4 хувийг модон эдлэлийн, 4,4 хувийг гутал хувцасны, 0,3 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, түгээсэн цэвэр ус, дулаан, монгол болон савхин гутал,

гэрийн модон тавилгын үйлдвэрлэлт 0,7 хувиас 2,1 дахин нэмэгдлээ. Харин бууз, хэрчсэн гурил, хүснэгт маягт, монгол дээлний үйлдвэрлэлийн хэмжээ 6,9 – 25,0 хувиар буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

1 дүгээр сард агаарын дундаж температур -14,0-өөс -27,0 хэм хүйтэн байсан бөгөөд хамгийн их дулаан Төвшрүүлэх, Эрдэнэбулган, Хотонт, Цэцэрлэг, Төвшрүүлэх сумдад 1,0-ээс - 1,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Өлзийт, Өгийнуур, Цахир сумдад -38,0-ээс -41,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Эрдэнэбулган, Хашаат, Хотонт, Төвшрүүлэх сумдын нутгаар 1,7- 2,2 мм цас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хангай, Чулуут, Тариат, Өлзийт, Өгийнуур, Цахир сумдад хур тундас ороогүй байна.

Статистикийн хэлтэс
2017.02.10

